| 3.2.5. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд | Нийт илэрсэн 52,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийн 62,1 хувь буюу 60,8 сая төгрөгийг барагдуулсан. | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Дотоодын хяналт, шалгалтын тайлан болон хөндлөнгийн хяналт, шалгалтын тайланг улирал тутамд нэгтгэн гаргаж сангийн санхүүгийн тайлантай тулган шалгаж нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу нэгтгэн хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн төлбөр зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээг улирал бүр НДЕГ-ын Хяналт шалгалтын газар хүргүүлэн ажиллаж байна.<br>НДЕГазрын шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн үлдэгдэл 1,0 сая төгрөгийг барагдуулсан ба хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчил байхгүй болно. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | | | | |
| ***Биелэлт 630 / 7 90 хувь*** | | | | | | | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлж, хариуг хугацаанд нь хүргүүлнэ. | 2022 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 81,5%-тай хэрэгжсэн байна | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | Тайлант хугацаанд дээд газрын тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг гаргаж, 2023 оны байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр биелэлтийг тайлагнаж, чиглэл, зөвлөмжийн биелэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь тайлагнаж хүргүүллээ. | 80 |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2022 онд 88,1 %-тай хэрэгжсэн байна. | Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д болон иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, тэдний тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа | Иргэд даатгуулагчид, аж ахуй нэгж байгууллагаас ирсэн санал, өргөдөл гомдлыг бүртгэж, “Бүртгэл хяналтын карт” хөтөлж, цохолт хийлгэж, холбогдох ажилтан, албан хаагчид хүлээлгэн өгч хуулийн хугацаанд нь шийдвэрлэх явцад хяналт тавин ажиллаа. Тайлант хугацаанд нийт 253 өргөдөл ирснээс 247 нь шийдвэрлэгдэж 6 өргөдөл хүлээгдэж байна.<br>Төрлөөр нь ангилан үзвэл:<br>- НДШ-тэй холбоотой- 64 | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тусгаж ажиллах. | - ЭМД-ын илүү төлөлт буцаан авах – 75<br>- Тэтгэвэртэй холбоотой - 8<br>- Тэтгэмжтэй холбоотой – 2<br>- Сайн дурын даатгалтай холбоотой-85<br>- Бусад асуудлаар-19 өргөдөл ирүүлж шийдвэрлэгдсэн байна.<br>Орон нутгийн 31-11 " Иргэд олон нийттэй харилцах төв"-д өргөдөл гомдол ирээгүй, Засгийн газрын 11-11 –д 2 өргөдөл бүртгэгдсэн ба мэдээллийн баазад 1 даатгуулагчийн мэдээлэл буруу, 1 нь тэтгэмжтэй холбоотой гомдол байсныг өдөрт нь шийдвэрлэсэн болно. | |
| 4.1.3. | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн байна. | Иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон нөхөн даатгалын лавлагааны хүсэлтийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс able программ, албаны имэйлээр хүлээн авч хариуг ажлын **3** хоногийн дотор гарган өгч хэвшээд байна. 2023 онд хэлтэст **658** иргэнээс лавлагааны хүсэлт ирж лавлагааг олгож үйлчилсэн. Үүнээс биечлэн **298**, QR кодтой **72**, хэлтэс хооронд Able программ ашиглан цахимаар дүүрэг, хэлтэс, сумдын байцаагч хооронд **288** иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна.<br>Архивын лавлагаа цахимжиж, аймаг, дүүрэг, сум хооронд Able програм ашиглан ажилласнаар даатгуулагчдад чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж чадаж байна. | 100 |
| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын | | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, тайланг | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль | Оны эцсийн байдлаар тус хэлтсийн орон тооны гүйцэтгэл 38 буюу 80,8 хувьтай байна. Тайлант хугацаанд байцаагч ажиллагсадын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх сул орон тоог нөхөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байх. | | үнэн зөв гаргаж хүргүүлнэ. | ажиллах боломжоор хангасан байна. | тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт тайлагнасан байна. | зорилгоор Хэнтий аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран ажиллаж сул орон тооны захиалгыг тухай бүр хүргүүлж, ерөнхий болон тусгай шалгалтыг зарлуулсан. Төрийн албаны салбар зөвлөлийн нэр дэвшүүлснээр сул байсан 3 орон тоог нөхсөн. 11 дүгээр сарын 08-нд зөрчилтэй байсан 3 албан хаагчийг төрийн албаны тусгай шалгалтад хамруулж зөрчлийг арилгасан.<br>Оны эхнээс сул орон тоонд 5 албан хаагчийг томилж, Мэргэжлийн хяналтын газраас 1 шилжин ирсэн ба тус хэлтсээс 2 албан хаагч өөрийн хүсэлтээр байгууллага хооронд Төрийн албаны тухай хуулийн дагуу шилжин ажилласан байна. | 100 |
| 4.1.5. | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүрэг, ажлын байрны үндсэн зорилтыг давхардуулахгүй байх, ажлын байрны гол үйл ажиллагааг тодорхой болгох. | Хэлтсийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байна. | Хэлтсийн дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна. | - Монголын цахилгаан холбоотой 05 дугаар сараас эхлэн хамтран ажиллах гэрээ байгуулан Нийгмийн даатгалын **70562212** дугаарыг **“Call center”** үйлчилгээнд холбон шаардлагатай байцаагч, албан хаагчийн албан тушаал, дугаарыг оруулан өгснөөр иргэд даатгуулагч хэрэгтэй мэдээлэл, зөвлөгөөг энгийн утасны тарифаар авах боломжтой болсон.<br>- Сумдын байцаагч нарын үйл ажиллагааг жигд чанартай болгох, байцаагчдын чадварыг нэмэгдүүлэх, хугацаатай тайлан мэдээ, судалгааг хугацаанд нь гаргах асуудлыг сайжруулах үүднээс 21 нэгжийг бүсчлэн 4 хувааж хэлтсийн даргын тушаалаар туршлагатай сайн байцаагчдаар бүсийн ахлагч томилсон. Бүсийн ахлагч нар нь хариуцсан сумдын байцаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаатай тайлан мэдээ, судалгааг хугацаандаа явуулсан эсэх, тухайн сумын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэхэд хяналт тавих тал дээр анхааран ажиллаж байна. | |
| 4.1.6. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Хэлтсийн ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийх, бүртгэлжүүлэх, тусламж үзүүлэх. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг бүрэн тайлагнасан байна. | ТАХ-ийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан ажиллах орчныг сайжруулах, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зэрэг дэв олгох, ахиулах боломж шаардлага хангасан төрийн албан хаагчдын мэдээ судалгааг гарган, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаа.<br>- Төрийн албаны тухай хуулийн хүрээнд 6 байцаагч шинээр зэрэг дэвийн нэмэгдэл олгох, 11 байцаагчийн зэрэг дэвийг ахиулахаар холбогдох материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, захирамж гаргуулж нэмэгдлийг зохих ёсоор тооцон олгож байна. Мөн улсын байцаагчийн эрх шинээр авсан 3 байцаагчийн цалингийн шатлалыг ахиулсан.<br>- Төрийн албаны тухай хууль болон дотоод журамд заасны дагуу 4 албан хаагчид 3,1 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.<br>- "Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын дүрэм" -ийн 10 дугаар зүйлийн 10,3 дахь заалт Хэлтсийн даргын 2023,08,02 А/17 тушаалаар магадлагч эмчид 2,5 сая төгрөг олгосон.<br>- Ахмадуудад Үндэсний уламжлалт Цагаан сарын баяраар 26 ахмадад 0,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.<br>- Хэлтсийн даргын 2023,09,28А/19 Ахмадын баярын хүндэтгэл үзүүлэх тухай 26 ахмадад 0,8 сая төгрөгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжлэг<br>- 26 албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт 2,3 сая төгрөг олгосон.<br>- Ахмадуудын судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийг баяжуулсан.<br>- Албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдийн судалгааг шинээр гаргаж “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулан ажиллаж байна. | |
| 4.1.7. | Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Хэлтсийн албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Хэлтсийн ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж хэвшсэн байна. | **Нийтдээ 7 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 115 албан хаагч хамрагдсан.**<br>- Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Үүнд: 2023-02-02 **“Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал”** сургалт 14 албан хаагч хамрагдсан.<br>- **“ Авлига, ашиг сонирхлын зөрчил”** сэдвээр 2023-03-16нд Хэнтий аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Буяндэлгэр, ахлах прокурор М.Отгонбаатар нар танхимаар 37 албан хаагч хамрагдсан.<br>- **“Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”** сургалт 2023-03-29нд НДЕГ-с зохион байгуулсан бөгөөд 3 албан хаагч хамрагдсан.<br>- Төрийн байгууллагын алба хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх байгууллагын соёлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн талаар АЗДТГазар мэдээлэл өглөө. 12 албан хаагч хамрагдлаа.<br>- 2023-06-02нд "Төрийн албан хаагчийн ёс зүй"- сургалт АЗДТГ, ТАЗ-с танхимаар зохион байгуулсан. Хамрагдсан албан хаагч 10<br>- Орон нутагт нийтлэг гарч буй авлига, ашиг сонирхлын зөрчилд анхаарах асуудалын талаар АЗДТГ-с 2023.06.15нд сургалт хийж 4 албан хаагч хамрагдсан.<br>- Төрийн албаны ёс зүйн тухай хууль<br>- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь<br>- Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн харилцаа ба хандлага, кэйсүүд 2023.10.16нд НДЕГ-ын ТГ-ын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Мө.Гэрэлмаа танхимаар явуулж 35 албан хаагч хамрагдсан. | |
| *"Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх **34** удаагийн сургалтад **468** албан хаагчийг хамруулсан. | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, албан хаагчдын мэдлэг ур чадвар дээшилсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтэс, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх **47** удаагийн цахим болон танхимын сургалтанд давхардсан тоогоор **1024** албан хаагчдыг хамруулсан.<br>**Үүний дотор:**<br>**Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх:**<br>- **"Нийгмийн даатгалын** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **байцаагч, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн даатгалын хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, иргэд даатгуулагчдад чанартай үйлчилгээ үзүүлэх”** зорилгоор хэлтсийн болон сумдын байцаагчдын сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 16-нд танхимаар зохион байгуулсан. Нийт 37 албан хаагч хамрагдсан.<br>Сургалтад:<br>НДЕГ-ын БХСГ-ын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Лхагвадорж цахимаар,<br>Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах Т.Ариун-Эрдэнэ,<br>Хэнтий аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Буяндэлгэр, ахлах прокурор М.Отгонбаатар,<br>Хэнтий аймгийн ЗДТГ-ын ХОХБХ-ийн мэргэжилтэн Ц.Бат-Эрдэнэ,<br>ГБХЗХГ-ын мэргэжилтэн Э.Анударь,<br>Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн мэргэжилтэн С.Наранцацрал нар оролцож сургалт, мэдээлэл хүргэлээ.<br>- **“Би нийгмийн даатгалын байцаагч”** сэдэвт ажил мэргэжлийн уралдааныг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж **37** албан хаагч хамруулсан.<br>**- “Алсын хараа 2050”** Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт сэдэвт сургалтад хамрагдан surgalt.gov.mn сайтад **26** албан хаагч бүртгүүлэн цахим сургалтыг судлан шалгалт өгч сертификат авсан.<br>**Монгол бичгийн сургалт:**<br>- Хэнтий аймгийн Эх хэлний зөвлөлөөс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санаачлан Насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулсан “Монгол бичгийн” 60 цагийн анхан шатны сургалтад **15** албан хаагч амжилттай суралцаж "**БАТЛАМЖ**" аа гардан авсан.<br>-НДЕГ-ын СБГ-ын дарга Б.Даваахүү 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх Нийгмийн даатгалын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, сургалт хийлээ. Сургалтад Хэлтсийн 35 албан хаагч хамрагдсан.<br>- Үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2023.10.19 ны өдөр "АРИУНГЭРЭГЭ" төрийн бус байгууллагын дэргэдэх "АЛТАН БОЛОМЖ" сургалтын төвтэй хамтран зохион байгууллаа. Тус сургалтад хэлтсийн **10** албан хаагч хамрагдаж сертификат авсан.<br>- НДЕГ-с зохион байгуулсан үндэсний монгол бичгийн цахим сургалтад 22 албан хаагч суралцаж байна. | |
| 4.2.2. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах; | | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд чиглэсэн **324** удаагийн сургалтад **18045** иргэд, даатгуулагчийг хамруулсан. | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. | Нийтдээ **288** удаагийн сургалтаар **17522** иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт, мэдэээлэл хүргэн ажилласан.<br>- ААН албан байгууллага, иргэд даатгуулагчдад чиглэсэн сургалтын хүрээнд **225** сургалт, уулзалт хийсэн. **11304** иргэд, даатгуулагчдад сургалт, уулзалтад хамрагдаад байна.<br>- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэд, малчдад чиглэсэн сайн дурын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх **38** сургалтыг ажлын байран дээр буюу багуудаар явж зохион байгуулснаар **5430** иргэд даатгуулагч сургалтад хамрагдсан.<br><br>- Ахлах ангийн сурагчид болон политехник коллежийн Оюутан сурагчдад зориулсан "Ирээдүйтэй даатгал" нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах **25** сургалтыг зохион байгуулж **788** сурагчийг хамруулсан. | 80 |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл<br>Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-нд мэдээлэл байршуулсан тоо, хандалтын тоо<br>Бэлтгэсэн нэвтрүүлэг**,** видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо<br>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, даатгуулагчид, ажил олгогчид мэдээлэл | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн тоо **24** , мэдээллийн төрөл.**6** | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд шуурхай хүргэсэн байна. | Хэнтий аймгийн ЗДТГ-ын фэйж хуудас, www.hentii.ndaatgal.mn вэб сайт, www.facebook.com/NDKHenti фэйсбүүкээр, "Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс" фэйж хуудсаар **70** мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГазраас бэлтгэсэн **60** төрлийн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд хүргэсэн ба давхардсан тоогоор **276,9** мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна.<br>➢ Нийт албан хаагчид НДЕГ-ын @sigomongolia фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээлэл авах, мэдээллийг цааш түгээх ажлыг мэдээлэл технологийн мэргэжилтэн хариуцан ажилласнаар нийт **33** албан хаагч НДЕГ-ын фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээллийг цааш түгээн ажилласан.<br>➢ Сайн дурын даатгуулагчдад зориулсан "**Та шимтгэлээ төлсөн үү"** гэх бүх сумдын дансны мэдээлэлтэй, шимтгэл төлөх заавартай постерийг сар бүр цахим орчинд байршуулж | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түгээхээр зохион байгуулсан арга хэмжээний төрөл, сурталчилгаа хийсэн тоо<br>Зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл | | | хэвшсэн.<br>➢ Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар Тэтгэврийн байцаагч Т.Наранчимэг, Тэтгэмжийн байцаагч Б.Алтансувд нар видёо мэдээлэл бэлтгэж "Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар"-ын пэйж хуудсаар танилцуулсан.<br>➢ Хэлтсийн дарга Н.Нямхатан "Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар"-ын пэйж хуудас, Хэнтий Житайм пэйж хуудсаар "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл"-ийн талаар ярьцлага, мэдээлэл хүргэлээ. | |
| *"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь үечилсэн дүгнэлтэд жилд 2-оос доошгүй удаа үнэлгээ хийсэн байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭХМТК-т хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь үечилсэн дүгнэлтэд үнэлгээ хийж эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар хэлэлцүүлсэн үечилсэн дүгнэлтийн 30-аас доошгүй хувийг хамруулсан байна. | Хэнтий аймгийн ЭХМК нь 2023 онд нийт **46** удаа хуралдаж, **2261** иргэний хувь хугацааг сунгах, шнээр оруулах, цуцлах, шилжүүлэх, зогсоох гэх мэт асуудлыг шийдвэрлэсэн.Үүнд:<br>Хэвээр сунгасан -1708<br>Хувь нэмэгдүүлэн сунгасан -157<br>Хувь бууруулан сунгасан – 95<br>Шинээр тогтоосон – 302<br>Цуцлагдсан –168<br>Буцаагдсан - 25<br>Хугацаагүй дахин магадласан – 85<br>Шилжиж явсан – 22<br>Шилжиж ирсэн – 10<br>**Хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх 5 өвчлөл:**<br>№ \| Өвчлөлөөр нь \| ХЧАлдалтын тоо \| Хувь<br>1 \| Сэтгэц \| 557 \| 21.1% | |

<table>
<tr><td rowspan="3"></td><td rowspan="3"></td><td rowspan="3"></td><td></td><td rowspan="3"></td><td></td><td><table><tr><td>2</td><td>Мэдрэл</td><td>440</td><td>16.7%</td></tr><tr><td>3</td><td>Гэмтэл</td><td>416</td><td>15.8%</td></tr><tr><td>4</td><td>Дотор</td><td>396</td><td>15.0%</td></tr><tr><td>5</td><td>Нүд</td><td>322</td><td>12.2%</td></tr><tr><td>6</td><td>Нийт</td><td>2131</td><td>80.8%</td></tr></table></td><td rowspan="3">100</td></tr>
<tr><td>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна.</td><td>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна.</td><td>Иргэд, даатгуулагчийн картын хяналтыг сайжруулах, хуралд ирсэн картын үзлэгт үнэлгээ өгөх, эмч нарын картын бичилтийг сайжруулах, мэдлэгийг дээшлүүлэх, өвчтөний биеийн байдлыг үнэн зөв дүгнэх, шинжилгээнүүдийг бүрэн хийлгэж дүгнэх зэрэг асуудлуудыг сайжруулах зорилгоор 2261 иргэний картад 3, 8 дугаар саруудад 175 иргэний өвчний түүхийн картад үечилсэн дүгнэлт хийж, хэлэлцүүлэг явуулсан.<br>Үүнд: Шинжилгээний бүрдэл дутуу 25, эпикризийн бичилт дутуу буруу 10, нас зөрсөн 2, үндсэн хаяг буруу 3, ВКК, ВТЭК-ийн шийдвэрийг зөрүүлж хольж бичсэн 18 нийт 58 зөрчил гарсан. Хурлын дараа эмч нарт гарсан алдааны талаар ойлгуулж, заавар зөвлөгөө өгч ажилласан.</td></tr>
<tr><td>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна.</td><td>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд тулгалт хийж цахим мэдээллийн санг бүрдүүлсэн байна.</td><td>2023 оны тайлант хугацаанд Эмнэлэг хөдөлмөр магадлалын цахим мэдээллийн сангийн бүрдэлд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр мэдээллийн цахим санг хувийн хэрэгтэй тулган шалгах хяналт, шалгалтын ажлыг 2 удаа хийсэн. Шалгалтаар:<br>- 2023 оны жилийн эцсийн тоон мэдээллээс нас барсан 8, шилжсэн 3, Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 5, цуцлагдсан 5 нийт 21</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэний мэдээлэлийг цахим санд хөдөлгөөн хийлгүй орхисон зөрчлийг илрүүлэн мэдээллийн баазад залруулан, хөдөлгөөнийг оруулан зөрчлийг арилгасан.<br>- Улсын бүртгэлийн мэдээллийн бааз ЭХМК-ын программд 2 даатгуулагчийн овог, нэр зөрсөн байсныг тулган шалгаж ЭХМК-ын мэдээллийн программд зөрчлийг арилган засварласан. Мөн нас барсан 1 иргэний мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсээс тодруулан шалгуулж зөрчлийг арилгаж ажилласан.<br>- Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хаягийн бүртгэлийн мэдээллийг шалган үзэхэд:<br>Улаанбаатарын харъяат – 15, Налайх дүүргийн -1, Багахангай дүүргийн -1, Дорноговь аймгийн -1, Дорнод аймгийн - 1 иргэн байсныг илрүүлэн ЭХМК-ын мэдээллийн баазад шилжих хөдөлгөөн оруулан зөрчлийг арилгасан. | |
| 4.3.2. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭХМТК-т хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна. | ЭХМК-ын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор хугацаагүй заалттай 360 иргэний хувийн хэрэг, бичиг баримтыг хянан шалгаж шилжиж явсан 2 иргэн байсныг илрүүлэн шилжих хөдөлгөөнийг цахим санд засаж зөрчлийг арилгасан.<br>ЭХМТК-той хамтран дахин магадлангийн шалгалтыг 5 дугаар сарын 8-14-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Хамтарсан магадлалын шалгалтаар нийт 1070 иргэн хамрагдах байсны 90 хувь нь хамрагдсан. Шалгалтаар:<br>- Хэвээр магадлагдсан – 696<br>- Сунгалт хэвээр магадласан - 57 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хувь, хугацаа дахин өөрчилсөн – 142<br>- Цуцлагдсан – 59<br>- Нас барсан – 2<br>- Шалгалтад хамрагдаагүй – 63<br>Шалгалтад хамрагдаагүй 63 иргэний 23 нь Улаанбаатар хотод ЭХМТК-д очиж дахин магадлалд орж хэвээр сунгагдсан. | 80 |
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна. | ЭХМК-ын үйл ажиллагаанд оролцогч эмч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор эмнэлэг хөдөлмөрийн магадлалын эмч нар дотор ижил мэргэжилтний үзлэгийг дотор, мэдрэлийн эмч нар, мөн Баян-Адарга, Норовлин сумын эмч нарын картад тулгуурлан хийсэн.<br>Эмч нарын ерөнхий дүгнэлт ойролцоо, этапны эпикриз дутуу, шинжилгээнд дүгнэлт өгч үздэггүй зэрэг алдаа илэрч байсан бол сүүлийн шалгалтаар 90-95% хангалттай үнэлэгдсэн.<br>ЭХМТК-оос 2023 онд дотор, мэдрэл, сэтгэц, чих хамар хоолой, гэмтэл мэс засал, эмэгтэйчүүдийн өвчний шинэчилсэн заалтаар 6 удаа цахимын сургалтууд хийсэн. ЭХМК-ын магадлагч эмч, гишүүд эмч нар тухай бүр сургалтад хамрагдан зөвлөгөө авч мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэн ажиллаж байна.<br>Эмнэлэг хяналтын болон сум өрхийн эмнэлгүүдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлал болон эмнэлгийн хуудас бичих журамтай холбоотой сургалтыг хийсэн мөн нүүдлийн хурлаар Бор-Өндөр суманд сургалт хийсэн байна. | |
| | | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд сайн туршлага нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж туршлага солилцсон байна. | | |

<table>
<tr>
<td rowspan="3">4.3.3.</td>
<td rowspan="3">Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэх</td>
<td rowspan="3"></td>
<td>Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана.</td>
<td rowspan="3">Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭХМТК-т хүргүүлнэ.</td>
<td>Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна.</td>
<td rowspan="2">Хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийг Эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах эмчилгээний талаар :<br>Сумдын эмч нар хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ тавих хяналтаа сайжруулж, эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж, ЭХМК-ын хурлаар эмчлэгч эмч өөрийн биеэр иргэдээ авчирч танилцуулж байна. Сэргээн засах тасгийн эрхлэгч Хатанбаатар эмчтэй хамтран ажиллаж физик эмчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нэмэгдүүлэн, эмчилгээнд бариа заслаас гадна зүү төөнүүр, хөдөлгөөн засал, татлага зэрэг эмчилгээний төрлийг нэмсэн нь үр дүнгээ өгч байгаа бөгөөд одоогийн байдлаар 32 иргэн хэвтэн эмчлүүлээд байна.<br><br>Сүүлийн 3 жилийн хөдөлмөрийн чадвар алдалтын судалгаа:
<table>
<tr><th>№</th><th>Сүүлийн 3 жилийн байдлаар</th><th>ХЧА иргэдийн тоо</th><th>Хэнтий аймгийн нийт хүн амд ХЧА эзлэх хувь</th><th>Улсын дундаж</th><th>Өмнөхөөс буурсан хувь</th></tr>
<tr><td>1</td><td>2020</td><td>2697</td><td>3.4</td><td>3.2</td><td>-1.0%</td></tr>
<tr><td>2</td><td>2021</td><td>2614</td><td>3.3</td><td>3.2</td><td>-3.1%</td></tr>
<tr><td>3</td><td>2022</td><td>2636</td><td>3.3</td><td>3.1</td><td>-0.8%</td></tr>
</table></td>
<td rowspan="3">80</td>
</tr>
<tr>
<td>Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна.</td>
<td>Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаатай болсон байна.</td>
</tr>
<tr>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна.</td>
<td>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссыг хурлын байраар</td>
<td>Хурлын байрны асуудлын талаар:<br>Хурлын байрны асуудлыг Аймгийн засаг дарга болон Нэгдсэн эмнэлэгийн удирдлагад удаа дараа танилцуулсан боловч бүрэн шийдэгдээгүй. Одоогоор байрны хүрэлцээ муутай гэсэн шалтгаанаар түр өрөөнд хурал явагдаж байна. Хурлын өрөөний асуудлаас</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангах, тохижуулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх, сургалт сурталчилгаа хийх нөхцөлийг бүрдүүлэх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх тоног төхөөрөмжөөр хангах зэрэг ажлыг зохион байгуулсан байна. | болоод иргэд хуралд 3 дахь, 4 дэх өдрийг дамжин 2 хоног зарцуулдаг байсныг нэгдсэн эмнэлгийн удирдлагуудтай хэлэлцэж 1 дүгээр хурлыг 3 дахь өдрийн 10-13 цаг, 2 дугаар хурлыг 12 цагаас эхлэн хуралдаж хэвшээд байна. Мөн өвлийн улирал цаг агаарын бэрхшээлийг үнэлэн дотооддоо хуралдаж ЭХМК-ын шийдвэрийг тухайн эмнэлэг дээрээ хэлэлцэн картыг 2-р хуралд илгээх мөн хурлыг цахимаар болон бичиг баримтанд тулгуурлан хийж эхэлсэн. | |
| 4.3.4. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн байна. | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын болон Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн чиглэлээр сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна. | Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолын хавсралт “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм” , Ерөнхий газрын даргын А/38 тоот тушаалын хавсралт “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам” -аар эмнэлэг хяналтын болон өрхийн эмнэлгүүд, Дархан, Баянмөнх, Галшар, Бор-өндөр сумдад 2023 оны 05 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд, 6 дугаар сард Норовлин, Дадал, Баян-Адарга, Биндэр, Батширээт, 8 дугаар сард Дэлгэрхаан, Жаргалтхаан, ХБУлаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдын эмч, мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулсан.<br>Мөн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аар батлагдсан Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Ерөнхий газрын даргын А/38 тоот тушаал “Эмнэлгийн хуудас олгох, хянах журам”-ын талаарх сургалтыг нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан. Сургалтад ЭМГазрын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтан, албан хаагчид болон нэгдсэн эмнэлгийн эмч, ажилчид оролцсон ба дээрх хууль журмуудтай холбоотой заавар, зөвлөгөөг өгсөн. | |
| | | | Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | | Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын болон Эмнэлэг хяналтын комиссын гишүүд, төрөлжсөн мэргэжлийн, сумын, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байна. | " Авлига, ашиг сонирхлын зөрчил" сэдвээр 2023-03-16нд Хэнтий аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Буяндэлгэр сургалт хийсэн.<br>- "Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалт 2023-03-29нд НДЕГ-с зохион байгуулсан.<br>- Цахимаар 2023 оны 06 дугаар сарын021-нд "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь " АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Б.Баяртөгс<br>- "Авлигын гэмт хэрэг" АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Г.Ундармаа | |
| *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, даатгуулагчийн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хангах | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай 99.92% нийцсэн. | Нийт даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн регистрийн дугаартай нийцсэн байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээж авахдаа шинээр ажилд орсон даатгуулагчийн мэдээллийг улсын бүртгэлийн "regweb" программтай тулган баталгаажуулан бүртгэж байгаа тул регистрийн дугаар, овог, нэр буруу орох эрсдэл гарахгүй байна.<br>Тайлант хугацаанд овог нэр, регистрийн дугаар зөрчилтэй **94** даатгуулагчийн мэдээллийг улсын бүртгэлийн REGWEB | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн овог /эцэг, эхийн нэр/-той 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн сантай 99.62% нийцсэн. | Нийт даатгуулагчийн овог /эцэг, эхийн нэр/ улсын бүртгэлийн мэдээллийн овог /эцэг, эхийн нэр/-тэй нийцсэн байна. | программаас шүүж зөрчлийг арилгуулж даатгуулагчийн мэдээллийг 100 хувь үнэн зөв хүлээн авч ажилласан. | 90 |
| | | | Тухайн онд идэвхтэй шимтгэл төлөгч даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй 100% нийцсэн байна. | 2022 онд даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй 99.95% нийцсэн. | Нийт даатгуулагчийн нэр улсын бүртгэлийн мэдээллийн нэртэй нийцсэн байна. | | |
| | | | Өмнөх онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчдын овог, нэр, регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай 95% нийцсэн байна. | | Өмнө онуудад шимтгэл төлж байсан даатгуулагчийн мэдээлэл улсын бүртгэлийн мэдээлэлтэй нийцсэн байх | | |
| 4.4.2. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байна. | 2022 онд ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.92% байсан. | Ажил олгогчийн үндсэн мэдээлэл буюу ЭЗҮАСА, өмчийн болон хариуцлагын хэлбэр, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Шинээр хамрагдсан **78** аж ахуйн нэгжийн материалыг улсын бүртгэлийн баазтай тулгаж мэдээллийн баазад үнэн зөв бүртгэсэн. Үйл ажиллагаа нь зогссон **72** аж ахуйн нэгжийн хөдөлгөөнийг мэдээллийн баазад оруулж зогсоох хөдөлгөөн хийсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлсэн байна. | | -Даатгуулагчийн үндсэн мэдээллийг зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг зөв хүлээн авсан байна.<br>- Тухайн ажил олгогч дээр нэг сар дээр нэг даатгуулагчийг нэгээс илүүгүйгээр тайланд тусгуулсан байна. | Албан журмын даатгуулагч шинээр **283** албан журмын даатгуулагч хамруулан даатгуулагчийн үндсэн мэдээллийг зөв хүлээн авч мэдээллийн баазад бүртгэсэн болно.<br><br>Ажил олгогчоос шинээр албан хаагч ажилд авсан тохиолдолд цахимаар албан тушаалд томилсон тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд авч ажиллаж байна. | 100 |
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна. | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байна | | |
| 4.4.3. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээж авахдаа шинээр ажилд орсон, сайн дурын даатгалын гэрээ байгуулсан даатгуулагчийн мэдээллийг улсын бүртгэлийн “regweb” программтай тулган баталгаажуулан бүртгэж байгаа тул регистрийн дугаар, овог, нэр буруу орох эрсдэл гарахгүй байна.<br><br>“Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг хийж программаар шүүгдсэн алдааг шалган тухай бүр залруулга хийж байна.<br>Санхүү бүртгэлийн тасагтай хамтран | 100 |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. | | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн | | Сайн дурын даатгуулагчийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийгээгүй байна. | санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн шалгасны үндсэн дээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар 478 даатгуулагчтай холбоотой зөрчил гарсныг шалган 132 даатгуулагчийн мэдээллийг засварлаж зөрчлийн шинжгүй мэдээллийн тайлбарыг бичиж хаасан болно. | |
| | | | Цахим хяналтын программ хангамжаар илэрч буй алдааг 100% нягталж залруулсан байна. | | Цахим хяналтын программ хангамжаар илэрч буй алдааг 100% нягталж залруулсан байна. | | |
| 4.4.4. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамжийн үйл ажиллагаа хэвийн явагдсан. | Нэгжийн дотоод сүлжээ, техник хангамж, серверийн найдвартай ажиллагааг хангаж гэмтэл, саатал гарсан тохиолдолд түргэн шуурхай илрүүлж хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг авсан байна. | Хэлтсийн байранд сервер 1, router 1, wifi router 2, switch 7, kiosk төхөөрөмж 1, компьютер, принтер хэлтэс 18, сумдад 22 –ыг ашиглаж байна. Өдөр дутамдаа сервер, дотоод сүлжээний төхөөрөмжүүд, компьютер, хэвлэгч төхөөрөмжүүдийн хэвийн байдлыг шалгаж доголдол гарсан тохиолдол түргэн шуурхай хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна. | 100 |
| | | | Программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж буй байдал, нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт өөрчлөлт цаг хугацаандаа хийгдсэн байна. | Нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг хугацаанд нь хийсэн. | Нэгжид ашиглагдаж буй программ хангамжуудын шинэчлэлт, өөрчлөлтийг цаг тухайд нь хийж байцаагч ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | НД-ийн үйл ажиллагаанд ашиглагддаг бүх программ хангамжуудын хэвийн ажиллагааг ханган программд өөрчлөлт орж шинэчлэгдсэн тухай засаж шинэчилсэн хувилбар update-г хийж ажиллаж байна. | |
| | | | МТТ-өөс батлан мөрдүүлж буй “Сервер компьютерийн оны | Оны эцсийн үйлчилгээний журмын хэрэгжилт хангагдсан. | Нэгжийн сервер компьютерийн оны эцсийн тохируулга үйлчилгээг журмын | 2015.12.07-ны өдөр баталсан “Сервэр компьютерт оны эцсийн үйлчилгээ хийх журам” ЖРМ-МТТ-05-2015-ын дагуу ерөнхий нягтлан бодогч А.Октябрь, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эцсийн үйлчилгээний журам”-ыг хэрэгжүүлсэн байна. | | дагуу бүрэн хийж тайланг цаг хугацаанд нь баталгаажуулан МТТ-д ирүүлсэн байна. | мэдээллийн технологийн мэргэжилтэн Б:Баярсайхан нар журам, дарааллыг чанд баримтлан хувиарт хугацаандаа МТТ-р ОЭҮ-г хийлгэж үйлчилгээний тойрох хуудсыг хөтлөн 2023.02.15 ны өдөр ММТ-д хүргүүлсэн.<br><br>- 2023 оны 02 дугаар сарын 02-ны 06 тоотын дагуу “ Хэрэглэгчийн компьютерын нууц үгийг сольсон тухай бүртгэл”, “Нийгмийн даатгалын багц програм хангамжийн хэрэглэгчийн эрхийн нууц үг сольсон тухай бүртгэл”-н хэрэгжилтийн тайлан мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн. | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байна. | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | | |
| ***Биелэлт 1655 / 18 91,9 хувь*** | | | | | | | |
| **Тав. Бусад ажил үйлчилгээ** | | | | | | | |
| 5.1. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэх | шаард лагагү й | Тарьсан модоо арчилж ургуулсан байх | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж нийт **138** мод тарьсан. | Төлөвлөгөөнд заагдсаны дагуу ажилтан албан хаагчид бүгд оролцон нийтийн эзэмшлийн талбайд мод тарьсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан **“Тэрбум мод”** үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж энэ онд нийт **100** мод нийтийн эзэмшил, хувийн хашаа, цэцэрлэгт хүрээлэн гэсэн газруудад тарьсан.<br>- 2023 оны 05 дугаар сарын 15-нд нийтийн эзэмшлийн талбайд 20 ширхэг мод суулгасан ба хашаанд амьдардаг албан хаагчид хашаандаа жимсний 20 ширхэг мод тарьсан.<br>- 2023 оны 10 дугаар сарын 13,14-нд **“Ид шидийн орон –Хэнтий”** төсөлд нэгдэж цэцэрлэгт хүрээлэнд 30 ширхэг агч мод, нийтийн эзэмшлийн талбайд нөхөн сэргээлт хийж 30 улиас тус тус тарьсан. | 100 |
| 5.2. | Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан | | Зохион байгуулсан ажлын | Эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн | Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос | 2023 онд эцэг эхийн зөвлөлийг шинээр шинэчлэн байгуулж, зохион байгуулах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах талаарх сургалт, ажил үйлчилгээ зохион байгуулах | | тоо | байгуулсан. | урьдчилан сэргийлж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах талаарх сургалт, ажил үйлчилгээ зохион байгуулах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байна. | ажлын төлөвлөгөөг Хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.<br>1. Байгууллагын дотоод журамдаа хүүхдийн талаар шинэ бүлэг үүсгэн 6 заалттай ажилчдадаа хүүхдийнхээ төлөө, цаг зав гарган ажиллах нөхцөл боломжоор хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй албан хаагчдад хөнгөлөлт чөлөө олгох болон, сурлага урлаг спортын өндөр амжилт гаргасан хүүхдүүдэд уралдаан тэмцээнд явахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг хүүхдэд ээлтэй заалтуудыг хамт олныхоо хурлаар хэлэлцэн баталж нэмж оруулсан.<br>2. Ажилтан албан хаагчдын хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд байхгүй байгаа гэж үзсэн.<br>3. Судалгаагаар 1 албан хаагч хөдөлмөрийн чадвар алдалттай хүүхэдтэй байна.<br>4. 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр **“Гэр бүлийн харилцаа ба Хүүхдийн хүмүүжил,”** сэдэвт сургалтыг ХХҮГ-ын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Ц.Туяасайхан явуулж нийт 37 албан хаагчдыг хамруулсан<br>5. **“Гэр бүлийн үнэ цэнэ хүүхдийн хүмүүжил”** 2023-03-20нд Лектор Ц.Азбаяр 3 албан хаагч хамрагдсан.<br>6. 2023 оны 6 дугаар сарын 1 ны **“Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-**өөр албан хаагчид хүүхдүүдээ баярлуулах ажлыг хамтран зохион байгуулснаар аав ээжийнхээ ажилтай танилцаж мөн хүүхдүүд эцэг эхдээ авьяас болон ур чадварыг харуулан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дуулж бүжиглэж нэг өдрийг хамт өнгөрүүллээ. Арга хэмжээнд 25 хүүхэд 20 аав ээжүүд оролцсон байна.<br>7. 2023 оны 11 дугаар сарын 13-ны өдөр **"Интернэт орчны хэрэглээ ба Хүүхдийн хүмүүжил,"** сэдэвт сургалтыг ХГБХГ-ын багш Мөнгөнбаяр , нийт 14 албан хаагчдыг хамруулсан. Сургалтад НҮБ-н хүүхдийн сангаас гаргасан цуврал хичээл болох Өсвөр насны хүүүхдийн Эрүүл мэнд, Хүүхдийн хоол тэжээл, Хүүхдийн асаргаа, Хүүхдийн Хамгаалал, Хүүхдийн Хөгжил боловсрол гэсэн үндсэн сэдвүүдээр хичээл сургалт авлаа.<br>8. 2023 оны 11 дүгээр сарын 13-нд Насан туршийн боловсролын сургагч багш З.Мөнхнасан урьж **"Мэдээллийн хэрэгсэл ба өсвөр нас"** сэдэвтэй сургалтад бүх ажилчин албан хаагчдаа хамруулсан. Энэ нь хүүхдийн интернэт орчинд хяналт тавих ухаалаг утасны хэрэглээг эцэг эхчүүд хэрхэн зөв удирдах, хэрхэн хянах, гэр ахуйн орчинд хүүхэдтэйгээ хэрхэн харьцах зэрэг сэдвүүдийг хөндлөө.<br>9. 2024 оны 11 дүгээр сарын 16 нд **"Гар утасгүй үдэш"** арга хэмжээ зохион байгуулж хүүхэд эцэг эхчүүдийн нэг оройг хамтран спорт тоглоом, уралдаан тэмцээн хүүхэд багачуудын дунд зохион байгуулж явууллаа. Нийт 02-17 насны 29 хүүхэд хамрагдсан. Арга хэмжээнд 2-5 насны дунд бөмбөг шидэх, 6-12 насны дунд буухиа, 13-17 насны хүүхдүүдийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дунд гар бөмбөгийн тэмцээн тус тус зохион байгуулж түрүүлсэн хүүхэд багачуудыг урамшууллаа. | |
| ***Биелэлт 200/2 100 хувь*** | | | | | | | |
| ***Нийт үнэлгээ 459,4 / 5 91,88 %*** | | | | | | | |

*Тайланг хянасан:* ***Төсвийн төвлөрүүлэн захирагч***

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ........................... / Л.МӨНХЗУЛ /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг*

..............................

*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА .......................... / Н.НЯМХАТАН /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* *.2023.12.05.*

*(огноо)*